

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-20

1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 5-12

2. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 12-17

3. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/ 17-20

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
04 дүгээр сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 38 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Н.Наранбаатар, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Э.Бат-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужин, С.Батболд.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан дөрөвдүгээр асуудал болох Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/ асуудлыг хойшлуулав. /12:40/

Нэг.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга О.Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Захиргааны удирдлагын газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга Б.Эрдэнэдалай, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Н.Энхболд, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ч.Гандирваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Б.Энх-Амгалан, Ц.Сэргэлэн нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба нар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн Ажлын албаны захирал Ж.Ариунболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 4
Бүгд: 9
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 54 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.9 хувийн ирцтэйгээр 13 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 38 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 4 сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу өнөөдрийн хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Ганибалын Амартүвшин ирсэн, Пүрэв-Очирын Анужин өвчтэй, Хавдисламын Баделхан ирсэн, Энхтайваны Бат-Амгалан ирсэн үү? Дуудаарай. Баагаагийн Баттөмөр орон нутагт томилолттой, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ орон нутагт томилолттой, Сүхбаатарын Батболд өвчтэй, Дашдондогийн Ганбат ирсэн байна, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн орон нутагт томилолттой байна, Салдангийн Одонтүяа гишүүн ирсэн байна, Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн байна, Дамдины Цогтбаатар гишүүн? Хэлээдхээрэй ирцдээ ор гээд. Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна, Жаргалтулгын Эрдэнэбат гишүүн орон нутагт томилолттой байна. Ирц 52.9 хувьтай байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2024 оны 4 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал.

2.Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, Засгийн газар 2024 оны 4 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

3.Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2024 оны 4 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Дөрөв дэх асуудал.Бусад асуудлуудын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Элчин сайдыг томилох, эгүүлэн татах, тухай асуудлаар зөвшилцөх тухай асуудал байсан. Энэ асуудал хуулийнхаа хугацаагаар болоогүй байгаа учраас энэ асуудлыг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4.1.3-д заасны дагуу горимын санал алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудлаа хэлэлцэж эхэлье. Ажлын хэсгийг оруулъя.

Нэгдүгээр асуудал.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг явуулъя.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

1. Гүрсэдийн Сайханбаяр Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал, Чулуунборын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Гомбосүрэнгийн Энхболд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа, Одоохүүгийн Ганбат Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа, Лхамдоржийн Нямдаваа цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа, Байгалийн Эрдэнэдалай Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа. Хуралдаанд оролцогчдыг танилцуулж дууслаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна.

Эхнийх Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг төслийн танилцуулгыг Сайханбаяр сайд хийе. Сайханбаяр сайдын микрофоныг өгье. 2 номерын микрофон.

Г.Сайханбаяр: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль

тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл болон Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай 2024 оны 16 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан танилцуулж байна.

Тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Батлан хамгаалахын болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж, хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтүүдийг тусгалаа. Үүнд:

Хуулийн зарим нэр томъёоны тодорхойлолт болон энхийг дэмжих ажиллагааны удирдлага зохион байгуулалттай холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон. Монгол Улсын Их Хурал Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг, энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч, багийн нийтлэг үүрэг зэргийг шинээр тодорхойлж нэмсэн.

Засгийн газрын болон гадаад харилцаа, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхтэй холбогдох зохицуулалтыг нарийвчлан тодорхой болгосон.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан тушаал, сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүнийг томилох, эгүүлэн татах болон энхийг дэмжих ажиллагаанд цэрэг, цагдаагийн баг оролцуулах, үүрэг гүйцэтгэх төрлийг шинээр нэмж тусгасан.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч, хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас нөхөн олговор

олгуулах, ээлжийн амралтаа эдэлж чадаагүй тохиолдолд мөнгөн урамшуулал олгох, үүрэг гүйцэтгэх хугацаанаасаа өмнө эргүүлэн татагдах тохиолдолд холбогдон гарах зардлыг тухайн албан хаагч өөрөө хариуцах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тодорхойлох зэрэг зохицуулалтыг зааж өглөө.

Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад Монгол Улсын оруулах хувь нэмэр, үүрэг оролцоо нэмэгдэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр энхийг дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд оролцох хууль, эрх зүйн орчин боловсронгуй болж, энхийг сахиулагчдын аюулгүй байдал, эрх зүйн байдал, үүрэг гүйцэтгэх, чадавх, оролцоо, төрөл нэмэгдэж, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх зорилтыг хангахад чухал түлхэц, нөлөө үзүүлэх юм.

Хууль тогтоомжийн хүрээнд хуулийн холбогдох эрх зүйн зохицуулалтын хүрээнд хуулийн төсөл болон холбогдох материалд олон нийтийн оролцоог хангах зорилгоор Батлан хамгаалах яамны цахим хуудас, Хууль зүйн яамны цахим хуудаст байршуулж, төрийн бус байгууллагуудаас санал авч, дэмжсэн болно.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Сайханбаяр сайдад баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү.

Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Би дараа нь асуулт асууя. Баделхан гишүүний микрофоныг өгье.

Х.Баделхан: Баярлалаа. Хуулийн төслийг ерөнхийдөө дэмжиж байгаа. Асуулт бол тэр энхийг дэмжих ажиллагаанд оролцохын тулд ер нь сонгон шалгаруулдаг юм байна л гэж ойлголоо. Олон улсын хэмжээнд сонгон шалгаруулалт явдаг юм уу ер нь? Тэр сонгон шалгаруулалтыг яаж зарладаг, яаж дүгнэдэг, яаж оролцдог талаар бас товчхон мэдээлэл өгчихвөл сайн байна.

Дараагийн асуулт бол ер нь тэр энхийг сахих ажиллагаанд оролцоноос манай улсад ер нь бас орлого олдог юм уу ер нь? Хэр хэмжээний орлого олдог юм, хэр хэмжээний зарлага гардаг юм? Оролцож байгаа хувь хүнд ер нь ямар хэмжээний бас орлого, зарлагын тийм тооцоо байдаг юм болов уу? Энэ тал дээр товчхон мэдээлэл өгвөл сайн байна. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Асуултад хэн хариулах вэ? Сайханбаяр сайд хариулъя. 2 номерын микрофоныг өгье.

Г.Сайханбаяр: Баярлалаа. Баделхаан гишүүний асуусан асуултад хариулъя.

Нэгдсэн Үндэстний Байгууллага цэрэг илгээгч орнуудын хооронд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд заасны дагуу гэрээ байгуулагддаг, санамж бичиг байгуулагддаг. Энэ санамж бичиг дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах мандаттай ажиллагаанд цэргийн баг, албан хаагчдыг явуулах тухай асуудлыг нарийвчлан тодорхойлсон байдаг.

Мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах

ажиллагаанд оролцогч цэргийн албан хаагчийг сонгон шалгаруулах журам гэж бас манай өөрийн гаргасан журам байгаа. Энэ дүрэмд нийцүүлэн гаргасан. Тийм учраас энэ сонгон шалгаруулалтын цэргийн албан хаагчдын материалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагад бид урьдчилан өөрсдийнхөө журмын дагуу шалгаруулсан материалаа Нэгдсэн Үндэстний Байгууллагад явуулдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллага тэрийг дахин нягталж үздэг. Олон улсын гэрээ конвенцыг зөрчиж байгаа зүйл байна уу, хууль зөрчсөн үйлдэл гаргаж байсан байна уу, өмнөх туршилага нь ямар байна гэх мэтчилнээр сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүдийг заасан энэ журмын дагуу шалгаруулж явуулдаг гэдэг нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа цэргийн баг, албан хаагчдад Нэгдсэн Үндэстний Байгууллага гэрээнийхээ дагуу нөхөн төлбөр олгодог. Энэ бол тухайн ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа зэвсэг, сум, галт хэрэгсэл, техник бүр дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын нөхөн төлбөрийн норматив гэж байгаа. Энэ нормативынхаа дагуу л энэ орлого, нөхөн төлбөр Монгол Улсад орж ирдэг. Энэ бол Сангийн яаманд шууд орж ирдэг. Үүнээс Засгийн газрын тогтоолоор нөхөн төлбөрийг зарцуулах журам гэж бас байгаа. Энэ журмынхаа дагуу Засгийн газар шийдвэрлээд явдаг ийм байгаа.

Хэмжээ дамжааны хувьд ер нь алба хаагчдын цалин гэж байхгүй. Нөхөн төлбөр гэж байдаг. Манайхан бас буруу, зөрүү ойлгодог. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд явсан цэргийн албан хаагчид цалин хөлстэй байдаг гэж. Монголд албан тушаалынхаа цалинг бүрэн авна. Дээрээс нь үүрэг гүйцэтгэснийхээ төлөө өдөр тутам томилолтын нөхөн төлбөр гэж юм авдаг. Үүгээрээ албан хаагчдад өөрсдөд нь бас ач холбогдолтой. 1 бүтэн жилийн үүрэг гүйцэтгэсэн цэргийн албан хаагч

30-35 сая төгрөг дунджаар Нэгдсэн Үндэстний Байгууллагаас үүрэг гүйцэтгэснийхээ төлөө нөхөн төлбөр авдаг.

Зэвсэг техникуудтэй холбоотой зүйлүүд бол нэг бүрчлэн өөр өөрийн үнэлгээ, нормативтай байдаг. Тэрнийхээ дагуу тооцогдож явдаг юм. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хариулт хангалттай юу? Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя. Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: 4 дүгээр заалт байна. Энэ өөртэй нь тохиролцсоны дагуу энхийг дэмжих ажиллагаанаас ирэх хүртэл хугацаанд эрх бүхий албан тушаалтан үндсэн албан тушаалаас нь өөр албан тушаалд шилжүүлэн томилж болно гэсэн нэг заалт байна. Энэ чинь манайхан эндээ албан тушаал хашиж байгаад томилогдоод явж байгаа шүү дээ тийм ээ? Одоогоор бол иртэл нь тэр нь хадгалагдаад л байж байгаа. Үүгээр шинээр бол тохиролцчихвол тэнд албаа хааж байх хугацаанд нь энд өөр ажилд томилчихоод ирсэн хойно нь тэн дээр нь тавина гэсэн ийм санаа байна уу тээ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн тухай заалт урьд нь байгаагүй санаад байна. Байсан уу? Байгаагүй байх тээ? Заавал цэргийн хүмүүсээсээ чөлөөлж байгаад явуулах юм уу, энгийн хүмүүсээс бас сонгож шалгаруулж болох уу? Энэ дээр асуулт байна.

Гуравд нь 7.1.6 дээр томилолтын зардлыг нь өгчхөөд сангуудад хуваарилдаг, одоо Зэвсэгт хүчнийхэд байж байгаа, цагдаагийнхан оролцоод ирэхээр цагдаагийн хөгжлийн санд бас тодорхой хувийг нь төвлөрүүлж хэмжээг нь Засгийн газар тогтоох юм байна. Энэ тоо хэмжээ ер нь өөрчлөгдсөн юм байгаа юу? Цаашидаа өөрчилнө гэж бодож байгаа юу? Одоогийн түвшиндээ явах уу гэсэн ийм 3

асуулт байна. Би хэлэлцэхийг нь дэмжиж байгаа.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? 2 номерын микрофон Батлан хамгаалахын сайд Сайханбаяр хариулъя.

Г.Сайханбаяр: Баярлалаа. Энхболд гишүүний асуусан асуултад хариулъя.

4.4 дүгээр заалт их чухал заалт. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд манай цэргийн албан хаагчид 20 гаруй жилийн хугацаанд 23 мянга орчим цэргийн албан хаагч оролцсон. Янз бүрийн албан тушаал дээр ажиллаж байгаа. Цэргийн албан хаагчдад явах боломж нээлттэй.

Тийм учраас тодорхой хүн хариуцдаг, тодорхой нарийн зэвсэг техник хариуцдаг чухал албан тушаалууд дээр өөрийг нь байхгүй үед 1 жилийн хугацаанд үндсэндээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд явах хугацаанд нь тэр ажил дээр цалгардал үүсэх, бас эзэнгүйдэх тийм асуудлууд гардаг учраас бид энэ асуудлыг цалинг нь бууруулахгүйгээр, тухайн албан тушаалтай адилтгах албан тушаал руу шилжүүлэн цалинжуулах зорилгоор энэ заалтыг оруулж ирсэн заалт.

Өөрөөр хэлэх юм бол цэрэг захирдаг албан хаагч явах юм бол цэрэг нь эзэнгүй болно. Техник, бусад байлдааны буудлага, харвалт хариуцдаг, жижүүрлэлт хариуцдаг албан хаагч нар явах юм бол тухайн байлдааны тайван цагийн байлдааны үүрэг гүйцэтгэх орон зай нь бас үгүйлэгддэг учраас үүнтэй холбоотой зохицуулалтыг шинээр тусгаж өгсөн байгаа 4.4 дээр. Энэ бол маш их ач холбогдолтой заалт.

Энэ дотроо бас тэр энгийн албан тушаалд гэдэг заалт бол энэ анх удаа орж ирж байгаа. Яагаад гэвэл Нэгдсэн Үндэстний Байгууллагаас бас Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах

ажиллагаанд эмэгтэй энгийн албан тушаалд нээлттэйгээр сонгон шалгаруулалт зарладаг. Энд нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах ажиллагааны туршилагатай манай албан хаагч нар бас оролцох, оролцож ч ирсэн байгаа. Энэ бол хуульчлагдаагүй явж ирж байсан. Энэ асуудлыг эрх зүйн хувьд нь зохицуулалт хийж өгч байгаа.

Ер нь тэр бүс нутагтаа нэлээн анхаарал татсан, энгийн иргэдийн асуудлыг зохицуулдаг, бусад ар тал, хангалттай холбоотой, аж ахуйтай холбоотой эдийн засгийн чиглэлийн үүрэг гүйцэтгэдэг ийм албан тушаалуудад манай Нэгдсэн Үндэстний Байгууллагын туршилагатай албан хаагчдыг авах сонирхол их байдаг. Зарим тохиолдолд нэр зааж ч ирдэг тохиолдлууд байдаг. Энэ сонгон шалгаруулалтад тухайн энгийн албан тушаалд цэргийн албан хаагчид, цагдаагийн албан хаагчдыг явуулж болох юм гэсэн үүднээсээ энэ хууль, эрх зүйн зохицуулалтыг оруулж өгсөн байгаа юм.

Энэ бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын мандаттай ялгаагүй ажиллагаа. Гагцхүү энгийн албан тушаалд цэргийн албан хаагчид энгийн энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж болох юм гэдгийг нь нээлттэй болгож өгснөөрөө онцлогтой. Бас чухал ач холбогдолтой гарцаа байхгүй эрх зүйн зохицуулалт хийх ийм шаардлагатай заалт орж ирсэн.

7.1.6-тай холбоотой асуудал бол энэ сангийн түвшин бол ер нь хэвийн явж байгаа. Өмнөхийн адил явж байгаа. Жил бүр хязгаараа батлуулдаг Сангийн яамаар. Бид 35 тэрбум төгрөгийн хэмжээнд Сангийн яамны баталсан хэмжээний хүрээнд гүйцэтгэлээ хангаад явж байгаа.

Ер нь энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын багт өнгөрсөн 4 жилд өөрчлөлт их ороогүй. Ливанд үүрэг гүйцэтгэж байгаа эмнэлгийн багийг эс тооцвол эмнэлгийн баг

нэмэгдэж орсон. Ганцаар үүрэг гүйцэтгэдэг энхийг сахиулагчдын орон нэмэгдсэн. Үүгээрээ өнөөдөр 11 оронд 900-гаад цэргийн албан хаагчид үүрэг гүйцэтгэж байгаа.

Тийм учраас сангийн орлого, зарлагад нөлөөлөх хэмжээний өөрчлөлт ороогүй гэдгийг хэлье. Дууслаа.

Б.Энх-Амгалан: Энхболд гишүүн тодруулъя. Энхболд гишүүний микрофоныг өгье. 1 минут.

Н.Энхболд: Үүрэг гүйцэтгэх газартаа сонгогдсон цагдаагийн албан хаагчид нэгдсэн удирдлагын доор цэргийн командлалынхаа удирдлагын дор явах юм байгаа биз дээ? Биеэ даасан янз бүрийн бүлэг, салаа, элдэв янзын юм байхгүйгээр явах нь л цагдаагаасаа сонгогдох болохоос очсон хойноо нэг л удирдлага дор ажиллана гэж ойлгох ёстой байна.

Дээр нь та нар бас нэмээд хэлчхээрэй. Хүмүүс асуугаад байдаг юм байна лээ. Энхийг дэмжих ажиллагаанд орж байгаа бие бүрэлдэхүүн бол бүгдээрээ сайн дурын үндсэн дээр, сайн дурын үндсэн дээр гэрээ байгуулаад, би сайн дурынхаа үндсэн дээр ийм ийм асуудал гарвал өөрөө хариуцна ч гэсэн үг байхгүй л дээ. Тэгэхдээ сайн дурын үндсэн дээр явна гэсэн ийм гэрээгээр явдаг гэдгийг бас хэлчих хэрэгтэй юм байгаа юм.

Б.Энх-Амгалан: Хариулах уу? 2 номерын микрофоныг өгье. Сайханбаяр сайд хариулъя.

Г.Сайханбаяр: Нэгдсэн Үндэстний Байгууллагад л байгууллагын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд явж байгаа цэргийн албан хаагч нар бол сайн дурын үндсэн дээр явах ийм хуультай. Энэ хуулиа л мөрдөөд явж байгаа. Энийг бас иргэдэд, нийгэмд ойлгуулах асуудал дээр анхааръя таны хэлснийг.

Цагдаагийн алба хаагчид бол тухайн сонгон шалгаруулалт юм уу, санал болгосон бүсээсээ шалтгаалаад тухайн цэргийн командлалдаа хамаарагдаад явна. Үүрэг гүйцэтгэлд нь тэс өөр. Цагдаагийн албан хаагч нар бол зэвсэг хэрэглэхгүй. Зөвхөн иргэд хоорондын зөрчлийг, хэв журам сахиулах ч байдаг юм уу тиймэрхүү үүргүүдийг гүйцэтгэдэг. Дангаараа цагдаагийн баг үүрэг гүйцэтгэх болох юм бол.../минут дуусав./

Б.Энх-Амгалан: Гүйцээж хариулъя. 2 номерын микрофон. 1 минут нэмж өгье. Сайханбаяр сайдын микрофон.

Г.Сайханбаяр: Үүрэг гүйцэтгэх онцлог нь өөр учраас энэ бол хуулийн хувьд заавал цагдаагийн багийн, цагдаагийн баг, алба хаагчдыг оруулахын тулд Хууль зүйн яам Нэгдсэн Үндэстний Байгууллагатай тусгай гэрээ байгуулна. Нэмэлт гэрээ байгуулна. Тэрнийхээ хүрээнд үйл ажиллагааны хүрээ, цар хэмжээг тодорхойлно. Ер нь үүрэг гүйцэтгэх онцлог нь бол их өөр. Манайх бол байлдааны, тусгай томилгоот өгөгдсөн үүрэг, даалгавруудыг ямар ч цаг үед биелүүлэхээр байдаг. Манайх бол гэрээгээ байгуулаад үндсэндээ 20-иод жил болчхож байгаа.

Цагдаагийн албан хаагч нар, баг оролцох асуудал бол эрх зүйн хувьд шинээр гарч ирж байгаа учраас энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагатай дүрмээр зохицуулагдсан санамж бичиг байгуулаад тэр хүрээнд үүрэг гүйцэтгэнэ. Тухайн ажиллагааны мишний онцлогоосоо шалтгаалаад цэргийн багтайгаа, тухайн хүчний командлалтайгаа хэрхэн яаж харилцаа.../минут дуусав./

Б.Энх-Амгалан: Би 4 асуулт асуугаадахъя.

Цагдаагийн байгууллагын албан хаагчид энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах

ажиллагаанд оролцсоноороо ямар давуу талыг өөрсдөө бий болгох юм бэ? Цагдаагийн байгууллагын албан хаагчдын оролцож байгаа энхийг сахиулах үйл ажиллагаа бол хэв журам сахиулах үйл ажиллагаа юм уу, эсвэл энхийг сахиулах үйл ажиллагааныхаа хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаа юм уу? Энэ талаар тодорхой хариулаач.

Хоёр дахь нь энэ үйл ажиллагаанд Онцгой байдлын албан хаагч нарыг оролцуулах бололцоо, боломж бий юү? Яагаад тэгж байна гэхээр одоо ингээд дэлхийд цаг уурын өөрчлөлт энд тэнд их гарч байгаа, үер усны аюул их гарч байгаа, газар хөдлөлт, гал, усны гашиун зовлон, хүчтэй салхи, шуурга болж байгаа энэ цаг үед Онцгой байдлын албан хаагчид энэ хохирлын голомтод ажиллаж бас туршилага суух шаардлага хэрэгцээ байгаа. Энийг би яагаад хэлж байна гэхээр Туркт болсон энэ үйл ажиллагаа дээр Онцгой байдлын албан хаагчид маш онцгой сайн ажиллаж, томоохон үнэлэмж авсан. Энд бас хүмүүсээ бэлтгэх талаар юм бодож байна уу?

Гуравдугаарт нь хохирлын дараа буюу дайн байлдааны дараа үүсэж байгаа эмнэлгийн үйлчилгээ, тусламжийн асуудлаар эмнэлгийн ротуудаа нэмэх талаар энэ дээр ямар юмнууд тусгагдаж байна?

Дөрөв дэх асуудал нь нэгэнт хохирол бий болсны дараа сэргээн босгох үйл ажиллагаа дээр хэрхэн инженерийн ротууд ажиллах вэ? Энэ дээр бол зөвхөн Батлан хамгаалах яамны инженер, саферийн ротууд ажиллах уу, эсвэл цагдаа болоод онцгой байдлын албан хаагчдыг татан оролцуулах уу? Ийм 1 4 асуултад тодорхой хариулаадхаач.

2 номерын микрофон Жанжин штабын дарга хариулъя. Ганбямба Генералын микрофоныг.

С.Ганбямба: Энх-Амгалан даргын асуултад хариулъя. Би сүүлийн 3

асуултад нь хариулчихъя. Эхний асуудал цагдаагийн асуудал учраас манай цагдаагийнх хариулах байх.

Онцгой байдлын байгууллагын алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах талаар асууж байна. Яг одоогийн байдлаар Зэвсэгт хүчин болон төрийн цэргийн байгууллагын алба хаагчид үүрэг гүйцэтгэж байгаа. Ялангуяа Зэвсэгт хүчний Жанжин штабаас төрийн цэргийн байгууллагад квот өгч байгаа. Хилийн цэрэг, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад квот өгөөд, онцгой байдлын байгууллагын алба хаагчид үүрэг гүйцэтгэж байгаа. Тухайн газар оронд ялангуяа Өмнөд Суданд өнөөдөр манайхан хойд мужид нь үүрэг гүйцэтгэж байгаа. Тэнд одоо Нил мөрөн үерийн нөхцөл байдалтай байгаа. Энд бас онцгой байдлын зарим алба хаагчдын туршилагыг бид ашиглаж байгаа ийм юм байгаа. Тэгэхээр онцгой байдлын алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд оролцох асуудал нь нээлттэй байгаа гэдгийг танд хариулъя.

Эмнэлгийн рот, инженерийн ротын асуудал Монгол Улсын Зэвсэгт хүчин ер нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд хэд хэдэн чиглэлээр цэргийн баг оролцуулахаар бэлтгэл хангаж байгаа. Үүний нэг нь хоёрдугаар шатын эмнэлгийн багийн асуудал байгаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас яг хоёрдугаар шатын эмнэлэг хэрэгцээтэй өнөөдөр ажиллагаа хараахан байхгүй байгаа.

Харин бид бусад улсуудтай хамтраад Ливанд явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд манай 4 хүнтэй эмнэлгийн бүлэг бусад улсуудын эмнэлгийн бүлэгтэй хамтарч шинээр 2023 оноос эхлээд үүрэг гүйцэтгэж байгаа. Цаашидаа бид эмнэлгийн ротыг оролцуулах бэлтгэлээ хангаж байгаа.

Инженерийн ротын хувьд мөн нэн чухал хариуцлагатай үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа дайн байлдаантай байсан

нөхцөл байдалд газрын мина, танк эсэргүүцэх миныг аюулгүй болгох эрсдэл өндөртэй алба байдаг. Бид аль болох эрсдэлээс алба хаагчдаа хамгаалахын тулд сэргээн босгох үйл ажиллагаа явуулах инженерийн ротын бэлтгэлийг хангаад хоёрдугаар шатын шалгаруулалтад орчихсон байгаа. Тэгээд энэ багийг оролцуулахын тулд бас нэлээдгүй төсөв хөрөнгийн хэрэгцээ шаардлага байгаа. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас оролцуулъя гэвэл бид тухайн үед нь бас Засгийн газарт асуудал тавиад энэ багийнхаа бэлтгэлийг хангаад орохоор бэлтгэлээ хангаж байгаа гэдгийг хариулъя. Хариулж дууслаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя.

Энхийг дэмжих ажиллагаанд, Гандиймаа гишүүдээ дууд. Энэ чинь нэг.../үг тасрав./

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулъя. Дараагийн асуудалдаа оръё.

13.05 цаг

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан хаагчдыг танилцуулъя.

Гүрсэдийн Сайханбаяр Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалахын яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал, Чулуунборын Гандирваа Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал, Гомбосүрэнгийн Энхболд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр танилцуулна. Сайханбаяр сайдын микрофоныг өгье.

Г.Сайханбаяр: Эрхэм Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 33-д Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар заасан.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалыг холбогдох Засгийн газрын гишүүдтэй хамтран баталж, Хууль тогтоомжийн тухай

хуульд заасан шаардлагын дагуу хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан зарим өөрчлөлтүүдийг дурдвал:

Алслагдсанд тооцогдсон цэргийн анги салбарт 5 ба түүнээс дээш жилийн хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид мөнгөн урамшуулал олгох эрх зүйн зохицуулалт.

Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчдад цалин хөлс олгох журмыг холбогдох Засгийн газрын гишүүн батлахтай холбогдсон эрх зүйн зохицуулалт.

Улсын хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа цэргийн албан хаагчийг албан үүргээ гүйцэтгэх, ажил үүрэг гүйцэтгэх хугацааг нь цэргийн албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох, цэргийн алба хаагчийн ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байхтай холбогдсон эрх зүйн зохицуулалт зэргийг тусгасан болно.

Уг хуулийн төсөл батлагдсанаар цэргийн алба хаагчийн нийгмийн баталгаа дээшилж, алслагдсан болон хөдөө орон нутагт байрлах цэргийн анги, салбарт тогтвор суурьшилтай ажиллах, цэргийн албаны хэвийн, аюулгүй, тасралтгүй үйл ажиллагаа хангагдах нөхцөл сайжирч, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлого баримт бичгийн Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилт болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заагдсан батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж үндэсний язгуур ашиг

сонирхолд тулгуурласан мэргэжлийн чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ гэсэн зорилт хангагдахад зохих нөлөө үзүүлж хууль тогтоомжийн нийцэл хангагдах юм.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд 2024 оны улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй болно.

Иймд Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэр гаргаж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Сайханбаяр сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү.

Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Дараа нь би асуулт асууя. Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя. Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Энэ үзэл баримтлалд нь зөвхөн алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт байгаа хүмүүсийн тухай ярьж байна уу, эс үгүй бол энэ чинь цэргийн цолны нэмэгдлийн тухай, хэзээ яаж олгож байх тухай тэр асуудлууд ерөөсөө тусаагүй юм байна тээ? Зөвхөн алслагдсанд тооцогдож байгаа ангиудтай холбоотой л асуудал байж гэж ойлголоо шүү дээ үзэл баримтлалд нь.

Хэрэв тэрнээс өөр юм байсан бол би бас санал оруулъя гэж бодож байсан юм. Тэгэхдээ үзэл баримтлалынхаа хүрээнд ярихгүй бол хэцүү л дээ.

Б.Энх-Амгалан: Хариултыг тодруулж хариулъя. 2 номерын микрофон. Жанжин штабын дарга Ганбямба хошууч генерал.

С.Ганбямба: Энхболд гишүүний асуултад хариулъя. Энэ Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулж байгаа энэ 7.1.22 дугаар заалт бол Засгийн газрын тогтоолоор алслагдсан тооцогдсон цэргийн анги, салбарт ажиллаж байгаа цэргийн алба хаагчдад үйлчлэхээр оруулсан байгаа.

Өнөөдөр Хилийн тухай хуулийн дагуу зөвхөн агаарын цэргийн салбарт ажиллаж байгаа алба хаагчид хамаарч байсан. Энэ хууль батлагдсанаараа хуурай замын, тусгай хүчний, мөн радио, электрон тагнуулын зарим ангийн алба хаагчид нэмэгдэж энэ 5 жил тутам мөнгөн урамшуулал олгох асуудал нь шийдэгдэж байгаа. Тэгэхээр нийгмийн хамгааллын асуудал цэргийн алба хаагчдад өргөн хүрээтэй болж байгаа гэж бас ойлгож болно. Хариулж дууслаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Нэмээд Сайханбаяр сайд хариулъя. 2 номерын микрофоныг өгье. Сайханбаяр сайд нэмж хариулъя.

Г.Сайханбаяр: Энэ алслагдсанд тооцох анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нарын нийгмийн хамгаалалттай холбоотой асуудал. Энэ 2016 онд Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичиг шинэчлэгдээд, батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг болсон батлан хамгаалах багц хуулиуд шинэчлэгдсэн, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай шинэ хуулийг бид өргөн барьж батлуулсан. Тухайн үед улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсантай холбоотойгоор яг цэргийн албан хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой 5 заалт царцсан. Яг чуулганы хаалтын хуралдаан дээр гишүүдэд танилцуулаад, Их Хурлын дарга протоколд тусгаад заасан заалтуудаас орж ирж байгаа зарим заалт нь энэ тусгагдаад явж байгаа юм.

Тухайлбал, энэ алслагдсанд тооцсон анги, салбаруудын жагсаалтыг дахин тогтоох, энэ журмыг Засгийн газар тогтоох. Энэ бол Хил хамгаалах

тухай хууль, Хилийн тухай хуулиар зохицуулагдаж байсан эрх зүйн харилцаагаар манай Зэвсэгт хүчний радио локацын анги салбаруудад ажиллаж байгаа албан хаагчдад зөвхөн тэд нарт олгож байсан. Одоо бид энийгээ зэвсэгт хүчний анги, салбаруудын алслагдсанд тооцох анги, салбарт ажиллаж байгаа алба хаагчдыг нийтээр нь хамруулах асуудлыг энэ дотор оруулж ирээд явж байгаа.

Мөн түүнчлэн энэ дотор тэр гадаадад суралцаж байгаа албан хаагчдын цалинтай холбоотой асуудал гээд, бас зарим нэг заалтууд нь бас үлдсэн байгаа. Тухайлах юм бол үзэл баримтлал дээр тусгагдсан цэргийн дээд цолтой офицеруудад тэтгэвэр чөлөөндөө гарсан үед нь цэргийн цолны цалинг олгоно гэсэн заалт бас Сангийн яам, бусад асуудлууд дээр дэмжигдээгүй учраас ер нь үзэл баримтлалын хүрээнд хөндөгдчихсөн. Гэхдээ хуулийн төсөл дээр орж ирээгүй байгаа гэдгийг тодруулж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Сайханбаяр сайдад баярлалаа.

Би 3 асуулт асуугаадахъя. Энэ Монгол Улс батлан хамгаалах салбартай 39 улстай хамтын ажиллагаатай. Одоогийн байдлаар 11 улсын цэргийн академи, их, дээд сургуулиудад монгол оюутнууд, сонсогчид, офицер, ахлагч нар суралцаж байна. Энд гадаадад суралцаж байгаа цэргийн албан хаагчдад үндсэн цалин нь ар гэрт нь олгогддог байх тэр зохицуулалт батлан хамгаалах багц хуулийг хэлэлцэж байх үед 2017 оны үед яригдаж байсан тэр маань яг хэвээрээ явж байгаа юу, үгүй юү? Энэ цалин чинь 100 хувь ар гэрт нь олгогддог ийм юм байна уу, байхгүй байна уу? Бас нөгөө хувьчлалаараа явчихсан 50 хувь, 40 хувь гээд байна уу? Энэ юу болж байна? Энийг хариулаадхаач.

Хоёр дахь нь дотоодод сурч байгаа сонсогч, ахлагч, офицеруудад бол сурч байгаа хугацааг нь бол ажилласан

жилд нь оруулж тооцдог. Гадаадад сурч байгаа сонсогч, ахлагч, офицеруудад энэ сурч байгаа хугацаа нь ажилласан жилдээ тооцогдох уу, үгүй юү? Энэ асуудал.

Гурав дахь нь. Сая журмыг шинэчлэн баталж оруулж ирнэ гэлээ жагсаалтууд. Тэр нь энэ дээрээ бас тусгах нь зөв байх шүү. Тэрийг та нар юу гэж бодож байна? Тэгэхгүй бол журмаа баталж оруулж ирэхгүй бол аль салбарыг алслагдсан анги, салбар гэж нэрлэх юм? Төвөөсөө хэдэн километр алслагдмал байгааг нэрлэх юм, эсвэл ямар онцлогтой ангийг нэрлэх юм гэдэг юм чинь бас тодорхой болж өгөхгүй бол болохгүй байх. Энэ 3 асуултад хариулаадхаач.

2 номерын микрофон. Батлан хамгаалахын сайд Сайханбаяр генерал хариулъя.

Г.Сайханбаяр: Байнгын хорооны дарга Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя.

Сонсогч, суралцагчдын цалин бол тухайн үед хууль хэлэлцэж байх үед нэлээн яригдсан. Тэр үед бас хувь процентын холбоотой асуудал ч гарч байсан. Одоо бол олгогдоод явж байгаа. Одоо бол бид Хууль зүйн сайд, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд, бүрэн эрхийнхээ хүрээнд асуудлаа шийдээд явж байгаа.

Хувийн хувьд Оросын Холбооны Улсад суралцаж байгаа академи, дээд сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчид бол цалингаа 100 хувь авч байгаа. Бусад улс орны хувьд тэтгэлэг өндөртэй холбоотойгоор 50 хувиас эхлээд л түүнээс дээш хувиар нийт олгогдох цалингийн дүнгээр нь олгож байгаа.

Энэ хууль батлагдсанаар гадаадад суралцаж байгаа цэргийн албан хаагч, сонсогч суралцагч цалингаа авах эрх зүйн

үндэс нь бүрэн авах эрх зүйн үндэс нь улам баталгаажиж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагчид суралцах хугацаа нь алба хаасан хугацаанд тооцогдоно. Хуульд заагдчихсан хуулийн заалттай. Цэргийн албаны тухай хуульд тусгагдсан энэ хуулийнхаа заалтаар явж байгаа.

Гуравдугаар асуудал. Энэ алслагдсанд тооцсон анги, салбарыг хэрхэн яаж зохицуулж байна вэ? Энийг журмаа яах вэ гэж байна. Ер нь энэ алслагдсанд тооцсон анги, салбарыг Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын дагуу сонгодог, тогтоодог. Тухайлах юм бол нийслэл Улаанбаатар болон төвлөрсөн сум суурин газраас тэдэн километр, Улаанбаатар хотоос тэдэн километрт байрласан гээд яг тэр журмынхаа дагуу энэ Зэвсэгт хүчнийхээ анги, салбаруудыг тэр журмын дагуу алслагдсанд тооцсон ангийн жагсаалтад оруулаад Засгийн газарт оруулаад шийдүүлээд, энэ хуулийнхаа хэрэгжилтийг хангаад явах юм байгаа юм.

Б.Энх-Амгалан: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, Сэргэлэн гишүүн асуултаа асууя. Сэргэлэн гишүүний микрофоныг өгье.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би сая Энх-Амгалан гишүүний асуусан асуулттай холбоотой л нэг юм асуух гээд байгаа юм. Би энийг дэмжиж байгаа юм. Энэ зөв.

Гэхдээ бүүр хууль дээрээ тодорхой заагаад өгчихвөл яадаг юм гэсэн бодол би юм асуух гээд байна л даа. Жишээлбэл, энэ алслагдсан гэдэг үг өөрөө энэ чинь ухагдахуун. Энийг хуулийн нэр томъёоны тодорхойлолт дээр яг тодорхой заасан юм байгаа юу одоо? Ямар нэгэн хууль дээр? Өөрөөр хэлбэл, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Цэргийн албаны тухай хууль дээр ч юм уу? Яг алслагдсан гэж

юуг хэлээд байгаа юм? Саяын Сайханбаяр сайдын тайлбарлаж байгаагаар бол Засгийн газрын баталсан журмаар аллагдсан анги, салбаруудынхаа жагсаалтыг батлаад явж байгаа гэж байгаа юм.

Гэтэл тэр жагсаалт нэг өөр хэрэг. Тэр аллагдсан гэсэн ухагдахуундаа тохируулж батлах ёстой. Ямар юмыг аллагдсан гэж хэлдэг юм бэ гэж. Жишээлбэл, хилийн отряд, заставын хувьд Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаар дээр байгаа учраас ямар ч тохиолдолд үгсийн сангаараа тэр өөрөө аллагдсан буюу хязгаар гэдэг юмандаа багтаад явчихдаг. Улсын хилийн шугам дээр гэхлээр л тухайн улсын нутаг дэвсгэрийн хамгийн захын цэг дээр байна гэдгээрээ аллагдсан гэдэг нь ойлгогдоод явчихдаг. Манай ерөнхий цэргийн анги, салбаруудын хувьд бол янз бүр л байгаа шүү дээ. Улаанбаатар, Налайх, юу байдаг юм энэ Төв аймгийн Сэргэлэн сум дээр хүртэл байж л байна. Тэгээд л цаашаагаа явж байгаа.

Тэгэхлээр энэ аллагдсан гэдэг ухагдахуунаа одоо энийг харин ашиглаад энэ Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа энэ дээрээ нэр томъёоны тодорхойлолт нь маш тодорхой оруулаад өгчих юм бол тэгээд энэ чинь насны л юм болно доо. Уг нь бол, тэгэхгүй тэгээд л Засгийн газар нэг өөрчлөхдөө аягүй сүүлдээ журам чинь батлагдахаа байх юм бол ямар ч Засгийн газар гараа билээ. Улс төржинө, янз бүрийн л юм байдаг.

Тэгэхлээр би бол хуульчлах нь зөв л гэж хэлэх гээд байгаа байхгүй юу. Энэ бол шинжлэх ухааны ухагдахуун шүү дээ. Баярлалаа. Одоо хууль байна уу, үгүй юү гэж асууж байгаа юм.

Б.Энх-Амгалан: Энэ үзэл баримтлалын хүрээнд энэ чинь их тийм зөрчөөд байх юм байхгүй биз дээ тээ? 2 номерын микрофон хариулт өгөөд,

протоколд үлдээчихье. Сайханбаяр генерал.

Г.Сайханбаяр: Сэргэлэн гишүүний асуултад тодруулга хийе.

Ер нь аллагдсанд тооцох асуудал Засгийн газар тогтооно гэсэн хуультай. Яг хууль дээр аллагдсанд тооцно гэдэг чинь яг юугаа хэлээд байна гэсэн хуулийн томъёолол байхгүй байгаа.

Гэхдээ хуулийнхаа үзэл баримтлал дотор энэ зөрчих асуудал байхгүй. Энийг тогтоолгоогүйтэй холбоотой зөрчих асуудал байхгүй. Би бас таны саналыг бас анхааралтай авлаа. Ер нь бас их ач холбогдолтой заалт. Тухайлбал, хуульчилчих юм бол бид нэг насны юм болчих юм байна гэсэн ийм санаа байгаа юм байна. Аж ахуйн нэгжүүдийг аллагдсанд тооцсон аж ахуйн нэгжүүд гэж бас Аж ахуйн нэгжүүдийн хуулиар зохицуулсан юм хум байдаг юм байна лээ. Манайхан бас үзэж, харсан юм байгаа. Яг цэргийн анги байгууллагуудыг аллагдсанд тооцох асуудлыг нь Засгийн газраар тогтоосон тэр аллалттай холбоотой, хэмжээтэй холбоотой асуудлаар нь тогтоогоод ингээд явж байгаа. Тэрийг нь барьж л хуульд оруулсан байгаа. Анхаарч авч үзье. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Хуулийн төслийг хэлэлцэх үед энэ асуудлыг анхааралдаа авна биз дээ. Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан хэлэх санал хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Одоо санал хураалт явуулна.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн оролцож, 66.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Сэргэлэн гишүүн танилцуулъя. Баярлалаа. Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсэгт баярлалаа.

13.20 цаг

2024 оны 4 сарын 18-ны өдөр Засгийн газраас өргөн мэдүүлсэн Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

2023 оны 3 сарын 23-ны өдрийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэж, дэмжсэн талаарх санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлсэн болно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Сайханбаяр, Ханджавын Батжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга байна уу? Байна. Пүрэвдоржийн Оюунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жаалжавын Ариунболд Боловсролын магадлан итгэмжлэх Үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга. Өөр хэн байна? Тэр өөрийгөө танилцуулчих. Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч Баярмаа тийм үү Боловсролын яамны? Протокол тэмдэглэлээ. Ийм ажлын хэсэг байна.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Сайханбаяр танилцуулна. 2 номерын микрофоныг өгье.

Г.Сайханбаяр: Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-25 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

2019 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-ын Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар батлагдаж, эхний 20 орон нэгдэн орсноор 2023 оны 3 дугаар сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр болсон Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дээд боловсролын салбарыг хамарсан анхны дэлхийн хэмжээний гэрээ юм.

2024 оны 3 дугаар сарын байдлаар Япон, Франц, Норвег, Швед, Их Британи зэрэг дэлхийн 28 улс энэхүү гэрээнд нэгдэн ороод байна. Энэхүү конвенцод нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн, зэрэг цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрээр суралцаж, эзэмшсэн мэргэжлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг олгодог.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс дэлхийн улс орнуудтай дээд боловсролын салбарт хамтран ажиллах, бүс нутаг хоорондын инновацыг дэмжих, дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд хувь нэмрээ оруулахаас гадна дээд боловсролын салбарт чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёлыг төлөвшүүлж, чанарын баталгаажуулалтын найдвартай байдал, уялдаа холбоо, чадавхыг бэхжүүлэх боломж бүрдэх юм.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар шинэчлэгдэн батлагдсан Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг баталгаажуулах, бүртгэх, олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд боловсролын зэрэг баримт, бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх, судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах, сантай байх чиг үүргийг боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн байгууллага хариуцан ажиллана.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: Сайханбаяр сайдад баярлалаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Нямаагийн Энхболд гишүүнээр тасаллаа. Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя.

Н.Энхболд: Энэ чинь ингээд нэгдээд орчихоор улс болгоноор нэгдээд орсон улс болгонуудаараа ярихдаа сургууль сургуулиар ярих уу, эс үгүй бол ерөөсөө л Монгол Улсын тогтолцоогоор авсан зэрэг дэвийг нь зөвшөөрөлцөөд явах юм уу? Ямархуу? Манайд чинь яг үнэнийг хэлэхэд их, дээд сургууль гэж нэрлэхэд бусад орнуудын ялангуяа хөгжилтэй том орнуудын олон 100 жилийн түүхтэй дээд боловсролын байгууллагуудтай харьцуулахад эрдмийн цол, зэрэг олгодог практиктай нь харьцуулахад хэцүү газрууд их олон байна шүү дээ.

Тэгэхээр яаж харилцан бие биеийнхээ энэ юмыг хүлээн зөвшөөрч, энэ харилцан туслалцаа, дэмжлэгийг үзүүлж байх юм? Ямархуу одоогийн байдлаар 22 улс л элсчихсэн байгаа юм байна шүү дээ. Эд нар чинь яг ямар практикаар, яаж бие биеийнхээ энэ зэрэг зиндаа юмыг харилцан хүлээн зөвшөөрөөд, бие биедээ тус дэм болоод явж байгаа яг практикийг нь хэрэгжүүлж эхэлсэн туршилагуудаас нь ганц нэг юм хэлээч. Ингээж ажилладаг юм байна лээ, манайх орвол ингэнэ, манайхыг ийм ийм улсууд зөвшөөрнө, тэр тэр улсуудынхыг манайх зөвшөөрнө гэсэн талаар.

Б.Энх-Амгалан: Хариулъя. 1 номерын микрофон Ханджавын Батжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга. Өөр хүн хариулах гээд байгаа юм уу? Хэн хариулах гээд байгаа юм? 2 номерын микрофоныг өгье. Пүрэвдоржийн Оюунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга.

П.Оюунаа: Тэгэхээр энэ конвенцод нэгдэн орох нь Монгол Улсын их, дээд сургууль, ер нь бол мэргэжлийн үндэсний шаталсан бүтэц дээр баталгаажуулж бүртгүүлсэн мэргэшилүүдийг бүгдийг нь конвенцод нэгдэн орсон 28 орнуудад хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагааг эхлүүлэх юм.

Тэгэхээр энэ үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд хамгийн эхний алхам нь бид нар Монгол Улсад байгаа мэргэжлийн бүх боловсролын баримт бичгүүдийг бүгдийг нь мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийнхээ дагуу бүртгэж, баталгаажуулж мэдээллийн сан үүсгэх ёстой.

Энэ мэдээллийн сан дээр бол бид нар яг чанарын баталгаажуулалт, чанарын шаардлага хангасан боловсролын баримт бичгүүд, дээд боловсролын сургалтын байгууллагуудыг бүртгэлжүүлж, баталгаажуулж мэдээллийн сан үүсгэнэ.

Үүний дараа бид нар дараагийн ажил нь бол энэ конвенцод нэгдсэн 28 орны орнуудтай харилцан зөвшилцөж, мэргэжлийн үндэсний шаталсан бүтцээ эхлээд хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй болно. Тэгэхээр одоо манай дээр байгаа магадгүй жишээлбэл мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийн 10 түвшинтэй байгаа. Үүний 8 дугаар түвшин дээр байгаа мэргэшил маань жишээлбэл, Франц орны Францын хувьд, Японы хувьд, Их Британийн хувьд яг ямар түвшинд харьяалагдах вэ гэдэг дээрээ эхлээд зөвшилцөж, харилцан ойлголцол бий болгоно гэсэн үг.

Ингэснийхээ дараа манай мэдээллийн сан баталгаажсаад, чанарыг нь чанарын шаардлага хангасан гэж үзсэн сургалтын байгууллагаас гарсан мэргэшилүүд, боловсролын баримт бичгүүдийг нөгөө улсынхаа боловсролын бичиг баримт, ялангуяа мэргэжлийн, үндэсний хүрээтэй нийцүүлэн баталгаажуулах ажлыг эхлүүлнэ гэсэн үг. Яг ийм практик алхмуудыг хийнэ.

Өмнө нь Монгол Улс бол бүсийн ийм дээд боловсролын конвенцод нэлээн нэгдсэн. Гэхдээ үүн дээр бол бас дорвитой үнэхээр харилцан хүлээн зөвшөөрүүлэх ийм арга хэмжээг бас хэрэгжүүлж амжаагүй байсан. Тэгэхээр энэ удаагийн конвенц маань дэлхий нийтийн хэмжээнд явдаг. Дээрээс нь

харилцан хүлээн зөвшөөрөхөөс гадна жижиг чадамжуудыг, жижиг гэрчилгээнүүдийг ч гэсэн хүлээн зөвшөөрөх боломжийг олгож байгаагаараа илүү давуу тал олгосон ийм конвенц болж байгаа.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя.

Н.Энхболд: Тэгэхээр асуудал бол конвенцод нэгдчихсэн гээд бүх улстай нэг зэрэг биш, ерөөсөө улс болгонтой мэргэжил юу гэдэг юм сургууль болгоноор шахуу ингэж явах нь байна шүү дээ тийм ээ?

Б.Энх-Амгалан: Тодруулж хариулъя. 2 номерын микрофон Оюунаа дарга.

П.Оюунаа: Тийм, тэгэхдээ бид нар хамгийн гол нь сургуулиудаасаа гэхээсээ илүүтэй бид нар мэдээллийн сан дээрээ яг баталгаажчихсан тэр мэргэшил, боловсролын баримт бичгүүдээсээ үйл ажиллагаагаа эхлэх хэрэгтэй болно гэсэн үг.

Б.Энх-Амгалан: Би нэг зүйл тодруулаадахъя. Энэ конвенц дээр байгаа нэг зүйл нь дээд боловсролын эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх юм байна, хэсэгчилсэн сургалтыг хүлээн зөвшөөрөх юм байна, сертификат жижиг дамжааны юмыг хүлээн зөвшөөрөх юм байна.

Цаашидаа яваад энэ дүрвэгсдэд ба шилжин суурьшсан этгээдийн хамрагдсан ашигласан сургалт ба эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрнө гэдэг ийм заалт яваад байна л даа. Энэ дүрвэгсдэд ба шилжин суурьшсан этгээд дээд боловсролд хамрагдах, дээд боловсролын хэлбэрийг хэрэгжүүлэх эсвэл хөдөлмөр эрхлэх боломж хайхад нь шударгаар үр дүнтэй үнэлэх, оновчтой журам боловсруулна гээд байдаг. Энэ чинь явж байгаад оролцогч улс болгон энд нэгдээ л бол албан ёсны мэдээллүүдээ конвенц хадгалагчид хүргүүлээд нэн

даруй энийг биелүүлэх ийм үүрэг хариуцлага хүлээх ийм заалттай юм байна шүү дээ.

Тэгэхээр бид нар дүрвэгсдийн юмыг энд чинь бас давхар нээгээд хаячхаж байгаа юм биш биз? Энийгээ хэлээдхээч. 2 номерын микрофон. Мааш тодорхой хариулаарай. Протокол үлдээж байгаа шүү.

П.Оюунаа: Энэнтэй холбогдуулаад бид нар конвенцод нэгдсэн гэдэг албан бичгээ ЮНЕСКО-гийн энэ конвенц хариуцсан олон улсын байгууллагад хүргүүлээд, тэрний дараа бид нар батламж гаргах ёстой. Энэ батламж дээрээ бид нар зөвшилцлөө тодорхойлно гэсэн үг. Яг аль хүрээнд явах вэ гэдгээ.

Б.Энх-Амгалан: Нэг юм анхаараарай конвенц батлахдаа. Энэ бол Монгол Улс дүрвэгсдийг хүлээж авдаг орон биш шүү. Тийм учраас энэ дээрээ ийм заалт хүлээн зөвшөөрчхөөд та нар энэ олон улсын конвенцод нэгдчихсэн, дүрвэгс ба шилжин суурьшсан этгээдийн хэсэгчилсэн сургалт, эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх ёстой, үүний хүрээнд та нар дүрвэгсдийг авах ёстой гэдэг ийм шахалтад орчих вий дээ за.

Гишүүд асуулт авч, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан санал хэлэх гишүүн байна уу?

Алга байна. Одоо санал хураалт явуулна.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 9 гишүүн санал хураалтад оролцож, 5 гишүүн дэмжиж, 55.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Амартүвшин гишүүн танилцуулах уу? Энхболд гишүүн танилцуулах уу?

Одонтуяа дарга танилцуулъя.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа танилцуулна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд болон ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

13.32 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР